

**ДОРНОГОВЬ АЙМГИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН  
2025 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН БИЕЛЭЛТ**

Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт	Гүйцэтгэлийн хувь
ЗОРИЛГО. УЛСЫН БҮРТГЭЛИЙН НЭГДСЭН ТОГТОЛЦООГ БҮРДҮҮЛЖ, ИРГЭНИЙ, ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН, ЭД ХӨРӨНГИЙН ЭРХИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ЦАХИМЖУУЛЖ, ТЕХНИК, ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ, ПРОГРАММ ХАНГАМЖИЙГ САЙЖРУУЛАХ.							
/“Алсын хараа-2050” зорилт 5.3, “Монгол Улсыг 2021-2025 онд хөржүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийн 5.3, “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”, Улсын бүртгэлийн байгууллагын 2025-2028 оны стратеги төлөвлөгөө/							
<b>ЗОРИЛТ1. ДЭВШИЛТЭД ТЕХНОЛОГИД СУУРИЛСАН ТӨРИЙН ЦАХИМ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ БАЙГУУЛЛАГА БАЙНА.</b>							
1.1.	Шинээр хэрэглээнд нэвтрүүлсэн Улсын бүртгэлийн цахим гэрчилгээгээр иргэд олон нийтэд үйлчилгээ үзүүлэх	Үйл ажиллагаа	Цахимаар олгосон эрхийн улсын бүртгэлийн гэрчилгээний тоо	0	5	Улсын бүртгэлийн цахим гэрчилгээ хэрэглээнд бүрэн нэвтрээгүй байгаа тул иргэд олон нийтэд үйлчилгээ үзүүлээгүй байна.	90%
1.2.	Иргэний үнэмлэх хэвлэх үйл ажиллагааг орон нутаг дахь зарим нэгжид хэвлэх боломжийг бий болгох, хууль эрх зүйн орчныг бүрдүүлэхэд санал хүргүүлэх	Үйл ажиллагаа	Хууль, эрх зүйн орчныг бүрдүүлэхэд хүргүүлсэн саналын тоо	0	1	Тус ажлын хүрээнд холбогдох газраас хууль, эрх зүйн орчныг сайжруулах санал авах тухай албан бичиг ирүүлээгүй тул холбогдох саналыг хүргүүлээгүй байна. Орон нутагт иргэний үнэмлэх болон үндэсний энгийн гадаад паспортын хэвлэх үйлдвэрийг байгуулах түүний ач холбогдол, шаардагдах хөрөнгийг шийдвэрлүүлэх талаар аймгийн Засаг дарга О.Батжаргалтай 2025 оны 04 сарын 09 өдөр уулзаж танилцуулсан бөгөөд шаардагдах төсөв хөрөнгийг орон нутгийн төсөвт суулган шийдвэрлэхээр тохиролцсон.	90%
1.3.	Иргэд, олон нийтэд тоон гарын үсэгний ач холбогдолыг сурталчлан таниулах, хэрэглээг нэмэгдүүлэх, шинээр олгох талаар арга хэмжээ зохион байгуулах	Үйл ажиллагаа	Зохион байгуулсан арга хэмжээний тоо	-	3	Тус хэлтсээс 2791 иргэнд, ХААН банк болон киоск машинаас 547, Төрийн цахим үйлчилгээний төвөөс 832 нийт 3338 иргэнд тоон гарын үсгийг олгосон байна. Тоон гарын үсгийн хэрэглээг нэмэгдүүлэх ач холбогдолыг иргэдэд таниулах, хэрэглээг нэмэгдүүлэх үүднээс арилжааны банк болон үүрэн телефоны Юнител компанийтай хамтран ажиллаж “one call” үйлчилгээний дуудлага хэсэгт хэрэглээ ач	100%

						холбогдлыг талаарх богино яриаг байршуулан ажиллаж байна.	
1.4.	Төрийн болон хууль хяналтын байгууллагад цахимаар лавлагаа, мэдээлэл үзүүлэх, хуулбар олгох үйлчилгээ нэвтэрсний дагуу орон нутагт цахимаар үйлчилгээ үзүүлэх	Үйл ажиллагаа	Цахимаар үзүүлсэн лавлагаа, мэдээллийн хувь	0%	100%	Төрийн байгууллага болон төрийн тодорхой чиг үүргийг гүйцэтгэж байгаа хуулийн байгууллагын үндсэн систем болон албан бичиг солилцооны дундын системээр дамжуулан 387 иргэний лавлагаа, мэдээллийг 100 хувь олгосон байна.	100%
1.5.	Шинээр үйл ажиллагаанд нэвтрүүлсэн гадаад паспорт захиалгын цахим машиныг орон нутагт хэрэглээнд нэвтрүүлэхэд сумдын удирдлагуудтай уулзалт зохион байгуулах, сурталчилан таниулах	Орон нутгийн төсөв	Зохион байгуулсан уулзалтын тоо	-	1	Тус ажлын хүрээнд аймгийн ЗДТГ-аас 2025 оны 4 дугаар сарын 12-ны өдөр зохион байгуулсан өргөтгөсөн хуралдаанд гадаад паспорт захиалгын машины хэрэглээ, ач холбогдол, шаардагдах төсөв хөрөнгийн талаар аймгийн удирдлага болон сумдын Засаг дарга наарт дэлгэрэнгүй танилцуулсан. Мөн тус аймагт зохион байгуулагдсан "Говийн бүсийн уулзалт"-ын үеэр тус асуудлыг танилцуулсан бөгөөд Замын-Үүд суманд 24 цагийн үйл ажиллагаатай цахим төв байгуулах саналыг гаргаж холбогдох хуралдаанаар хэлэлцүүлсэн.	100%
1.6.	Хуулийн этгээдийн улсын бүртгэлийг харьялал харгалзахгүй бүртгэх талаар ирүүлсэн чиглэлийн дагуу арга хэмжээг авч хэрэгжүүлэх	Үйл ажиллагаа	Харьялал харгалзахгүй бүртгэсэн хуулийн этгээдийн тоо	0	5	Орон нутгийн хэмжээнд хуулийн этгээдийн улсын бүртгэлийг харьялал харгалзахгүй бүртгэх асуудлын талаар УБЕГ-аас нэгдсэн чиглэл ирээгүй тул харьялал харгалзахгүй бүртгэл хийгдээгүй байна.	90%
1.7.	Хаягийн болон газар, үл хөдлөх эд хөрөнгийн дундын мэдээллийн сан байгуулах, өөрчлөлт оруулах, хаягийн мэдээллийн сангийн нэгдсэн системийг хэрэглээнд нэвтрүүлэхэд орон нутгийн зүгээс авч хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах	Үйл ажиллагаа	Газар, үл хөдлөх эд хөрөнгийн хаягийн дундын мэдээллийн сан үүсгэх ажилтай холбоотой авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо	2	2	Тус ажлын хүрээнд 2025 оны 05 дугаар сарын 26-ны өдөр аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газартай уулзалт зохион байгуулж газар, үл хөдлөх эд хөрөнгөд гэрчилгээ олгох асуудал, гадаадын хөрөнгө оруулалттай хуулийн этгээдийн шилжилт хөдөлгөөний асуудал, хаягийн асуудал болон иргэнд өмчлүүлсэн газрын мэдээллийн сангийн зөрүүтэй байдлыг арилгах дундын мэдээллийн сан үүсгэх ажлыг хамтран гүйцэтгэхээр тохиролцсон. Уулзaltaас гарсан үр дүнг тэмдэглэлээр баталгаажуулж харилцан тохиролцсон арга	100%

							хэмжээний дагуу цаашид хамтран ажиллах төлөвлөгөөг боловсруулаад байна.	
ЗОРИЛТ 2. ОРЧИН ҮЕИЙН ШИНЭ ТЕХНИК, ТЕХНОЛОГИ, МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙГ ҮЙЛ АЖИЛЛАГААНДАА НЭВТРҮҮЛЖ, ТӨРӨӨС ИРГЭН, ХУУЛИЙН ЭТГЭЭДЭД ҮЗҮҮЛЭХ УЛСЫН БҮРТГЭЛИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХҮРТЭЭМЖ, ШУУРХАЙ БАЙДЛЫГ НЭМЭГДҮҮЛНЭ.								
2.1.	Улсын бүртгэлийн хэлтсийн ажлын байрны байршлыг сайжруулах, стандартад нийцүүлэх ажлыг зохион байгуулах	Орон нутгийн төсөв	Зохион байгуулсан ажлын тоо	-	1	Tус ажлын хүрээнд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлээд байна.  - Сайншанд сумын хэмжээнд ажлын байрны судалгаа явуулж "Саруул талын өргөө" ХХК-ийн удирдлагатай уулзалт зохион байгуулж одоо баригдаж буй барилгын зохион байгуулалттай танилцаж, 350 м2 талбайг түрээслэх талаар санал солилцсон. - Аймгийн Засаг дарга О.Батжаргалтай 2025 оны 05 дугаар сарын 29-ны өдөр уулзаж дээрх түрээсийн байрны талаар санал хүсэлтээ гаргасан бөгөөд уулзалтын үр дунд түрээсийн төлбөрийн тодорхой хувьд дэмжлэг үзүүлэхээ мэдэгдсэн. - Үүний дагуу УБЕГ-ын Санхүү аж ахуйн хэлтэст төсвийн тодотголд санал оруулахаар 2025 оны 05 дугаар сарын 15-ны өдрийн 18/345 дугаар албан бичиг хүргүүлээд байна. - Зүүн бүсийн анхдугаар хуралдаанд тус хэлтэст шинээр officissын байр барих хэрэгцээ шаардлагыг танилцуулж - Дээрх хуралдааны үеэр Хууль, зүй дотоод хэргийн сайд хүрэлцэн ирсэн бөгөөд аймгийн харьяа газар, агентлагуудтай хийсэн уулзалтын үеэр мөн барилгын асуудлыг тавьсан бөгөөд 5 тэр бум төгрөг шаардлагатай байгаа талаар танилцуулсан.	100%	
2.2.	Эд хөрөнгө, хуулийн этгээд, иргэний улсын бүртгэлийн үйл ажиллагааг сайжруулах, алба хаагчдын ажлын бүтээмжийг нэмэгдүүлэх үйлчилгээний сэтгэл ханамж,	Үйл ажиллагаа	Эд хөрөнгө, хуулийн этгээд, иргэний улсын бүртгэлийн үйлчилгээг үзүүлэхэд өөрт байгаа мэдээллийг иргэдээс авахгүй, хурууны хээг уншуулан улсын бүртгэлийн үйлчилгээг хүнд сурталгүй, түргэн шуурхай үзүүлж процесийн дахин инженерчлэх ажлыг дэмжин иргэний улсын 9887 бүртгэл, Эд хөрөнгийн 3410 бүртгэл, хуулийн	50%	100%			100%

	хүртээмжийг дээшлүүлэх зорилгоор хэрэгжүүлж буй процесийн дахин инженерчлэлийн ажлыг дэмжин ажиллаж хэлтсийн хэмжээнд хөтөлбөрийн хэрэгжилтийг ханган ажиллах						этгээдийн улсын бүртгэлийн 929 үйлчилгээ нийт 14226 бүртгэлийг гүйцэтгэн ажилласан.	
2.3.	Сумдын ЗДТГ-тай хамтран "Танд ойрхон төрийн үйлчилгээ" арга хэмжээ зохион байгуулах	Үйл ажиллагаа	Сумдад зохион байгуулсан арга хэмжээний тоо	4	13	Tайлант хугацаанд нийт 8 суманд 17 удаагийн арга хэмжээ зохион байгуулж ажилласан. Үүнд <ul style="list-style-type: none"> <li>- Сайхандулаан суманд 02 дугаар сарын 03-нд, 5 сарын 20-нд,</li> <li>- Эрдэнэ суманд 04 дугаар сарын 29-ны өдөр, 06 дугаар сарын 06-нд,</li> <li>- Даланжаргалан суманд 02 дугаар сарын 17, 18, 03 дугаар сарын 19-25-ны өдрүүдэд,</li> <li>- Хатанбулаг суманд 06 сарын 03-06-ны өдрүүдэд,</li> <li>- Өргөн сум 02 дугаар сарын 15, 04 дүгээр сарын 10-ны өдрүүдэд,</li> <li>- Иххэт суманд 05 дугаар сарын 23-ны өдөр,</li> <li>- Улаанбадрах суманд 01 дүгээр сарын 21, 05 дугаар сарын 19,20-ны өдрүүдэд нээлттэй хаалганы өдөрлөг,</li> <li>- Сайншанд суманд 05 дугаар сарын 01-ний өдөр Хуульчийн пробоно өдерлөгийг тус тус зохион байгуулж нийт 1652 иргэнд улсын бүртгэлийн үйлчилгээг үзүүлсэн байна.</li> </ul>	100%	
2.4	Сумдын улсын бүртгэгч наарт үндэсний энгийн гадаад паспортын захиалга хүлээн авах, түгээх үйлчилгээний эрхийг нээлгэж орон нутгийн иргэдэд төрийн үйлчилгээг түргэн шуурхай хүргэх	Үйл ажиллагаа	Үндэсний энгийн гадаад паспорт захиалах боломжтой болсон сумдын тоо	2	12	Төрийн үйлчилгээг түргэн шуурхай, чирэгдэлгүй хүргэх зорилгоор 13 сумдад үндэсний энгийн гадаад паспорт захиалах үйлчилгээг нээж 93 иргэнд үндэсний энгийн гадаад паспорт олгоод байна. Гадаад паспортыг сумын иргэдэд эрсдэлгүй, аюулгүй, шуурхай хүргэх зорилгоор "Монгол шуудан"-гийн Дорноговь аймаг дахь салбартай гэрээ байгуулан "Дотоодын энгийн шуудан үйлчилгээ"-ний хамгийн бага тариф болох	100%	

						4650 төгрөгөөр хүргэлтийн үйлчилгээг үзүүлж байна.	
2.5.	Хуулийн этгээдийн бүртгэл хийх эрхийг холбогдох албан хаагч наарт нээлгэж орон нутгийн иргэдэд төрийн үйлчилгээг түргэн шуурхай хүргэх	Үйл ажиллагаа	Хуулийн этгээдийн бүртгэл хийх эрхтэй болсон улсын бүртгэгчийн тоо	10	2	Айраг сумын улсын бүртгэгч Б.Уранчимэг, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэгч Б.Номин-Эрдэнэ нар нь эрх зүйч мэргэжилтэй бөгөөд хуулийн этгээдийн улсын бүртгэл хөтлөх эрх нээлгэхээр 2025 оны 01 дүгээр сарын 08-ны өдрийн 18/02 дугаар албан бичиг, 2025 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн 18/21 дугаар албан бичгээр тус тус хүргүүлсэн. УБЕГ-аас хуулийн этгээдийн улсын бүртгэл хөтлөх эрх олгох тушаал гарахаар хулээгдэж байна.	90%
2.6.	Алслагдсан баг, хороо болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үйлчилгээ үзүүлэх боломжийг бүрдүүлж зөөврийн интернэт сүлжээг бий болгох ажлыг зохион байгуулах	Үйл ажиллагаа	Зөөврийн интернет сүлжээгээр хангагдсан сумдын тоо	4	9	Зөөврийн интернэт сүлжээгүй сумдын судалгааг гаргасан бөгөөд төхөөрөмжгүй 10 сумдыг төхөөрөмжээр хангах асуудлаар аймгийн ИТХ-ын дарга Н.Алдарбаяртай уулзант зохион байгуулсан. Тус асуудлаар аймгийн ЗДТГ-ын орлогч дарга Б.Бат-Эрдэнэтэй уулзсан бөгөөд сумдын Засаг дарга наарт чиглэл хүргүүлэхээр харилцан тохиролцсон. Мөн Айраг болон Дэлгэрэх сумдад ажиллах үеэр сумын Засаг дарга наарт зөөврийн төхөөрөмжийн хэрэглээ ач холбогдлыг дэлгэрэнгүй танилцуулж шаардагдах төсөв хөрөнгийг шийдвэрлүүлсэн.	90%
2.7	Хууль хяналтын болон төрийн байгууллага, иргэн, хуулийн этгээдэд эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлтэй холбоотой мэдээлэл, лавлагaa өгөх, нотлох баримтын хуулбар хүргүүлэх	Үйл ажиллагаа	Хууль хяналтын болон төрийн байгууллага, иргэн хуулийн этгээдээс лавлагaa мэдээлэл, нотлох баримтын хуулбараар үйлчилсэн үйлчилгээний тоо	10	15	Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй хууль хяналтын байгууллага (Авлыгатэй тэмцэх газар, Цагдаагийн газар болон Сум дундын анхан шатны шүүх)-д нийт 13 лавлагaa, 8 нотлох баримтыг хуулбарлан нийт 21 удаа үйчилгээ үзүүлсэн байна.	100%
2.8.	Улсын бүртгэлийн үйлчилгээний цахим машин (Киоск)-ийн тоог нэмэгдүүлж, киоскоор үзүүлэх улсын бүртгэлийн үйлчилгээ,	Үйл ажиллагаа	Улсын бүртгэлийн үйлчилгээний цахим машин /Киоск-/ны нэмэгдүүлсэн тоо	2	2	Дорноговь аймгийн Замын-Үүд сум, Хатанбулаг сумын Хангийн боомтод төрийн цахим үйлчилгээний киоск машиныг байршуулсан. Хагас жилийн байдлаар Дэлгэрэх, Сайншанд, Сайхандулаан сумдад киоск машиныг шинээр худалдан авах төсөв хөрөнгийг орон нутгийн төсөвт тусгуулсан.	100%

	хүртээмжийг нэмэгдүүлэх						Mөн аймгийн "ХҮРДАН" төвийн захирал Б.Ган-Эрдэнэтэй 2025 оны 04 дүгээр сарын 15-ны өдөр уулзаж тус газарт ашиглагдаж буй киоск төхөөрөмжөөр дамжуулан улсын бүртгэлийн үйлчилгээг үзүүлэх, байршилыг нэмэгдүүлэх чиглэлээр хамтран ажиллахаар харилцан тохиролцож Сайншанд сумын иргэд олноор цуглах зах, худалдааны төв, төмөр замын вогзалуудад байрлах ХҮРДАН төвийн төхөөрөмжөөр дамжуулан хүргэж үйлчилгээний тоог 4-өөр нэмэгдүүлсэн.	
2.9.	Улсын бүртгэлийн зөөврийн төхөөрөмж ашиглан үзүүлэх боломжийг бүрдүүлж тоног төхөөрөмжийг хэрэглээнд нэвтрүүлэх	Орон нутгийн төсөв	Хэрэглээнд нэвтэрсэн хөдөлгөөнт төхөөрөмжийн тоо.	0	1	Зөөврийн тоног төхөөрөмжийн үнийн судалгааг гаргаж аймгийн удирдлагуудад танилцуулсан бөгөөд шаардлагатай төсөв болох 275 сая 600 мянган төгрөгийг шийдвэрлүүлэхээр аймгийн ИТХ-ын дарга Н.Алдарбаярт 2025 оны оны 18/78 дугаартай албан бичгийг хүргүүлсэн. Орон нутгийн төсвийн хөрөнгөөр шийдвэрлүүлэхээр шаардлагатай арга хэмжээг зохион байгуулан ажиллаж байна.	90%	
2.10.	Улсын бүртгэлийн хэлтсийн 2025 оны үйл ажиллагаанд эрсдлийн үнэлгээ хийх	Үйл ажиллагаа	Эрсдлийн үнэлгээний батлагдсан төлөвлөгөөний тоо	1	1	Улсын бүртгэлийн хэлтсийн 2025 оны үйл ажиллагаанд тохиолдож болзошгүй эрсдэлийн тоо 13 байгаа бөгөөд эрсдлийг бууруулах төлөвлөгөөг боловсруулан баталсан. Төлөвлөөний дагуу эрсдлийн үнэлгээ гүйцэтгэж үзэхэд нөлөөллийн ба хэмжилтийн үнэлгээ маш бага-7, дунд үнэлгээтэй эрсдэл-6 тус тус үнэлэгдсэн.	90%	
		Үйл ажиллагаа	Эрсдэл бууруулсан хувь	75%	90%	Эрсдлийг бууруулах арга хэмжээний дагуу 2025 онд аймгийн нэгдсэн эмнэлэг, төрийн албан хаагчийн эмнэлгийн явуулын үйлчилгээгээр эрт илрүүлэгт 2 удаа хамрагдаж, албан хаагчдын нийгэм, эрүүл мэндийн асуудалд анхаардаггүй эрсдлийн эрсдлийн үнэлгээг бууруулсан. Монгол шуудан ХК-тай гэрээ байгуулан, 7 хоногт 2 удаа гадаад паспорт, иргэний үнэмлэх болон бусад материалыг бүх сумдад хүргүүлж ажилласнаар эх нотлох баримт алдагдах эрсдлийн үнэлгээг бууруулан нөлөөллийн ба хэмжилтийн үнэлгээ маш бага-9, дунд үнэлгээтэй эрсдэл-4 болгсон үр дүн гарч эрсдэл буурсан байна.		

2.11.	Хэрэглэгчийн хийх ажлыг байгуулах	Үнэлгээ зохион	Үйл ажиллагаа	Хэрэглэгчийн үнэлгээ хийлгэсэн тоо	1	1	<p>Эхний хагас жилийн байдлаар 176 иргэнээс сэтгэл ханамжийн судалгаа авсан. Улсын бүртгэлийн үйлчилгээний чанар хүртээмжийн асуулгад 100% хүссэн үйлчилгээгээ авч чадсан. Улсын бүртгэлийн ажилтны соёл, үйлчилгээний асуулганд Улсын бүртгэлийн ажилтны харилцаа, хандлага ёс зүй, мэргэжлийн ур чадварыг 91.9 хувь буюу "сайн" гэж үнэлгээ өгсөн байна.</p> <p>"Үйлчилгээний заалны агааржуулалтын нөхцөл муу, үйлчилгээний заалны талбай бага байгаа нь үйлчилгээ авахаар хүлээж байгаа иргэдэд хундрэлтэй байна" талаар санал ирүүлсэн.</p>	100%
2.12.	Улсын бүртгэлийн багц хуулийн нэмэлт өөрчлөлтийн төсөлд санал хургуулэх		Үйл ажиллагаа	Хургуулсэн саналын тоо	2	3	<p>Тус арга хэмжээний хүрээнд дараах эрх зүйн баримт бичигт санал хургуулсэн байна. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>- Иргэний улсын бүртгэлийн тухай хуульд гэрлэлт дуусгавар болсны бүртгэл, эцэг эхийн овог өөрийн нэр солих бүртгэл,</li> <li>- Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хууль болон Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль,</li> <li>- Хуулийн этгээдийн нэр баталгаажуулах журам,</li> <li>- Хуулийн этгээд, түүний салбар төлөөлөгчийн газрын улсын бүртгэл хетлөх журам,</li> <li>- Тамга тэмдэг хийлгэх, үйл ажиллагаанд хяналт тавих, лавлагaa олгох журам,</li> <li>- Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл зэрэг холбогдох хууль, дүрэм, журмын төслийг албан хаагчдад танилцуулж, саналыг холбогдох газруудад тус тус хургуулсэн.</li> </ul>	100%
2.13.	Орон нутгийн хэмжээнд төрийн эрх бүхий байгууллагын шийдвэрээр хуулийн этгээдийн бүртгэлд хориг тавих, цуцлах арга хэмжээг хэрэгжүүлэх		Үйл ажиллагаа	Хуулийн этгээдийн улсын бүртгэлд хориг болон тавьсан цуцалсан тоо	5	6	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын шийдвэрээр 8 хуулийн этгээдийн улсын бүртгэлд хориг тавих тухай шийдвэр ирснийг тухай бүр мэдээллийн санд тусгаж ажилласан.	100%

2.14	Орон нутгийн хэмжээнд бүртгэсэн иргэний улсын бүртгэлийн нэмэлт өөрчлөлт оруулах, засварлах, нөхөн бүртгэх арга хэмжээг хэрэгжүүлэх	Үйл ажиллагаа	Нэмэлт өөрчлөлт оруулах, засварлах, нөхөн бүртгэх бүртгэлийн тоо	251	154	Иргэд болон улсын бүртгэгч нараас ирүүлсэн 37 иргэний өргөдлийн дагуу мэдээлийн санд бүртгэлийн алдааг засварласан. Мөн УБЕГ-ын архивын газраас ирүүлсэн 1078 алдаатай бүртгэлийг алдааг мэдээллийн сан болон цахим архивын санд тулган шалгалт хийж хувийн хэрэг эх нотлох баримтыг үндэслэн тайлант хугацаанд 68 алдаа засварлаад байна.	90%
------	---	---------------	--	-----	-----	--	-----

**ЗОРИЛТ 3.УЛСЫН БҮРТГЭЛИЙН МЭДЭЭЛЛИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, НЭГДСЭН САНГИЙН НУУЦЛАЛЫГ ХАНГАН, ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГЫГ ХЭРЭГЖҮҮЛНЭ.**

3.1.	Эд хөрөнгө, хуулийн этгээд, иргэний улсын бүртгэлийн үйл ажиллагаанд хяналт шалгалаат хийх	Үйл ажиллагаа	Хяналт шалгалтын тоо	3	6	Бүртгэлийн үйл ажиллагаанд хяналт шалгалаат хийх телөвлөгөө боловсруулан хэлтсийн даргаар батлуулж, төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу эхний хагас жилд хийж гүйцэтгэх ажлуудыг бүрэн дуусгасан. Өргөдөл, санал гомдлын мөрөөр 30 удаа, телөвлөгөөт хяналт шалгалтыг 2 удаа нийт 32 удаагийн хяналт шалгалтыг хийсэн. Өдөр дутмын болон урьдчилан сэргийлэх хяналт шалгалтыг тогтмол хийж иргэний улсын бүртгэлийн чиглэлээр 947, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн чиглэлээр 83, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн чиглэлээр 25 нийт 1055 бүртгэлд хяналт шалгалаат хийж 89 зөрчил илрүүлж арилгуулах арга хэмжээ авч ажилласан байна.	100%
3.2.	Эд хөрөнгө, хуулийн этгээд, иргэний улсын бүртгэлийн мэдээллийн санг цэгцлэх арга хэмжээг зохион байгуулах	Үйл ажиллагаа	Эд хөрөнгө, хуулийн этгээд, иргэний улсын бүртгэлийн мэдээллийн санг цэгцэлсэн хувь	2%	5%	Иргэн болон эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн мэдээллийн санг цэгцлэхээр УБЕГ-ын Мэдээллийн технологийн газрын дарга Б.Анхбаярт аймгийн хэмжээнд 1988-2011 онд нас барсан иргэдийн мэдээлэл, аймгийн хэмжээнд иргэнд өмчилсөн газрын мэдээллийн баазыг цахим хэлбэрээр авахаар 2025 оны 05 дугаар сарын 29-ний өдрийн 18/329 дугаар албан бичиг хүргүүлээд байна. Тус ирүүлсэн мэдээллийн дагуу нэгдсэн байдлаар дун шинжилгээ хийж шаардлагатай засварыг гүйцэтгэх ажлын хэсэг байгуулан ажиллааар төлөвлөж байна.	90%
3.3.	Улсын бүртгэлийн хэлтсийн компьютер, түүний дагалдах техник, тоног төхөөрөмжийг үе	Үйл ажиллагаа	Шинэчлэгдсэн техник, тоног төхөөрөмжийн тоо	5	8	Зөөврийн интернэт сүлжээгүй 10 сумын судалгааг гаргаж удирдлагад хүргүүлсэн ба Айраг болон Дэлгэрэх суманд сумын Засаг даргын хөрөнгө оруулалтаар сүлжээний төхөөрөмж, зөөврийн	90%

	шаттайгаар шинэчлэх, сайжруулах					компьютерийг олгохоор шийдвэрлэсэн. Мөн Замын-Үүд сумын засаг дарга болон ЗДТГ-ын даргатай харилцан тохиролцож тус суманд үйл ажиллагаа явуулж буй 3 бүртгэгчийн суурин компьютерийг шинэчлэхээр ажиллах байна.	
3.4.	Серверийн өрөөний тоног төхөөрөмж, дагалдах хэрэгсэлд засвар үйлчилгээ хийх	Үйл ажиллагаа	Серверийн өрөөний тоног төхөөрөмжид засвар үйлчилгээ хийсэн тоо	0	1	Серверийн өрөөний тоног төхөөрөмжийн хэвийн ажиллагааг хангах ажлын хүрээнд эд хөрөнгийн улсын бүртгэлийн сервер байрлах үндсэн компьютерийг сольж сайжруулсан.	90%
3.5.	Архивын баримтын хадгалалт хамгаалалтын нөхцөлийг сайжруулах	Үйл ажиллагаа	Хадгалалт хамгаалалтын хэвийн үйл ажиллагааг ханган ажилласан хувь	75%	95%	Архивын өрөө, тасалгаа хүрэлцээгүй, зайд талбай багатай нягтаршуулсан шүүгээ байршуулах боломжгүй, хувийн хэрэг ил задгай байгаа эрсдлийг бууруулж зарим модон шүүгээ, шаардлагатай материалыг устгаж цэгцлэн 23 м <sup>2</sup> талбайг сүл чөлөөтэй болгосон. Энэхүү талбайн хананд архивын баримтын хадгалалт, хамгаалалтыг сайжруулах, сейфны асуудлыг өртөг багатай зардлаар шийдвэрлэж ханын төмөр тавиурыг төмрөөр угсрал байршуулж баримт материал хадгалах шүүгээг нэмэгдүүлсэн. Мөн иргэний архивын ажиллагаагүй болсон нягтаршуулсан шүүгээг хөдөлгөөгүй байршуулж хананд дахин төмрөөр тавиар хийх тесөвийг гаргасан бөгөөд шаардагдах хөрөнгийн талаар Улсын бүртгэлийн нэгдсэн архивын газрын дарга болон Улсын бүртгэлийн ерөнхий газрын дарга наарт 2025 оны 05 сарын 30 өдрийн 18/396 дугаар албан бичиг хургуулж холбогдох асуудлыг шийдвэрлүүлээд байна.	100%
		Үйл ажиллагаа	Архивт шүүгээ нэмэгдүүлсэн тоо	0	5		100%
3.6.	Хуулийн этгээдийн мэдээллийн санг цэгцлэх зорилгоор төрийн эрх бүхий байгууллагуудтай хамтран төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн зөрчлийг арилгах ажлыг зохион байгуулах	Үйл ажиллагаа	Зөрчил арилгасан хувь	1	3	Хагас жилийн байдлаар дараах хуулийн этгээдүүдийг зөрчлийг арилгуулсан байна. Үүнд: - Зэвсэгт хүчиний 336 анги, - Өргөн сумын соёл, спортын төв, - Замын-үүд сумын ЗДТГ, - Улаанбадрах сумын ЭМТ, - Дэлгэрэх сумын ЗДТГ-ын зөрчлийг хяналтын улсын байцаагчаар зөрчил хянан шийдвэрлүүлж зөрчлийг арилгасан.	100%

						Mөн хуулийн этгээдийн улсын бүртгэлийн сан болон аймгийн Татварын газрын мэдээллийн санд регистрийн дугаар зөрүүтэй 2 хуулийн этгээдийн мэдээллийг шалгуулан зөрчлийг шийдвэрлэн Татварын газарт хариуг хүргүүлсэн.	
3.7.	Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг ханган ажиллах	Үйл ажиллагаа	Тайлагнаж, байршуулсан мэдээллийн тоо	828	830	Шилэн дансны тухай хуулийн дагуу 2025 оны 05 дугаар сарын байдлаар төлөвлөгөөний дагуу нийт 268 мэдээллийг хугацаанд нь байршуулсан.	100%
3.8.	Эцсийн өмчлөгчийн мэдээллийн үнэн зөв байдлыг хангах, чанарыг сайжруулах ажлыг зохион байгуулах	Үйл ажиллагаа	Эцсийн өмчлөгчийн мэдээлэл бүртгэгдсэн тоо	0	10	Хагас жилийн байдлаар эцсийн өмчлөгчийн мэдээллээ бүртгүүлээгүй дараах 5 ХХК-ийн мэдээллийг бүртгээд байна. Үүнд: - "Алтанбаян буурал" ХХК, - "Гоё мөрөн" ХХК, - "Марал шанд" ХХК, - "Энхномин говь", - "Гурван баян ширээ" ХХК Мөн "АЕ логистик" ХХК –ийн гаргасан хүсэлтийн дагуу эцсийн өмчлөгчийн мэдээлэл буруу бүртгэдсэн байсныг хуулийн этгээдийн мэдээллийн санд зөв болгож засварласан.	100%

**ЗОРИЛТ 4. ХАМТЫН АЖИЛЛАГААГ ӨРГӨЖҮҮЛЭХ, ТӨРИЙН БОЛОН ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГУУДЫН УЯЛДАА ХОЛБОOG САЙЖРУУЛАХ**

4.1.	Алслагдмал бус нутгуудад төрийн үйл ажиллагаа явуулж байгаа хилийн цэргийн анги болон бусад хил хамгаалах чиг үүргийн болоод хилийн бүсэд үйл ажиллагаа явуулж буй төрийн байгууллагууд, тэдээрийн ажилтан, алба хаагчдад улсын бүртгэлийн үйлчилгээг түргэн шуурхай үзүүлэх	Үйл ажиллагаа	Төрийн байгууллага хоорондын харилцааг сайжруулах, үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэхээр зохион байгуулсан арга хэмжээний тоо	1	2	Алслагдсан сум болох Хатанбуудаг сумдан үйл ажиллагаа явуулдаг хилийн цэргийн 0168 дугаар ангийн захирагч Цолмонбаяртай уулзалт хийж тус ангийн зардлаар тухайн суманд нээлттэй хайлганы өдөрлөгийг 7 дугаар сарын эхний 7 хоногт зохион байгуулахаар бэлтгэл ажлыг хангаад байна. Мөн төрийн байгууллага хоорондын уялдааг сайжруулах үүднээс аймгийн ГХБХБГ-тай хамтран тус суманд дээрх арга хэмжээг зохион байгуулах талаар сумын ЗДТГ-т албан бичиг хүргүүлсэн.	80%
4.2.	Хил орчимд уул уурхай, тээвэр ложистикийн үйл ажиллагаа эрхэлж буй аж ахуйн нэгж байгууллагын ажилчид, тээвэрчид, хил орчимд	Үйл ажиллагаа	Төрийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэхээр зохион байгуулсан	1	2	Тус ажлын хүрээнд Хатанбулаг суманд гадаад паспортын захиалгын үйлчилгээг анхлан нэвтрүүлж тухайн суманд үйл ажиллагаа явуулж буй Хангимандал боомт орчмын уул уурхай, тээвэр ложисикийн үйл ажиллагаа явуулж буй ААНБ-ын	100%

	оршин суух туслах хүчний үүрэг бүхий малчин иргэдэд улсын бүртгэлийн үйлчилгээг түргэн шуурхай үзүүлэх		арга хэмжээний тоо			албан хаагчдад түргэн шуурхай үйлчилгээ үзүүлсэн.	
4.3.	"Шинэ Хоршоо" хөдөлгөөн, бичил уул уурхайн нөхөрлөлүүдийг дэмжих зорилгоор малчид болон мал бүхий иргэд, бизнес эрхлэгчид, бусад чиг үүргийн хувийн хэвшлийн байгууллагуудтай олон талт хамтын ажиллагааг явуулах	Үйл ажиллагаа	Хоршоо, нөхөрлөл бусад хувийн хэвшлийн байгууллагуудтай хамтран гүйцэтгэсэн арга хэмжээний тоо	1	2	Xagас жилийн байдлаар "Шинэ хоршоо" хөдөлгөөний хүрээнд аймгийн хэмжээнд нийт 235 хоршоо байгуулгадж шинээр бүртгэсэн. Мөн шинээр 16 бичил уурхайн нөхөрлөл байгууллагдсаныг хууль журмын дагуу хуулийн этгээдийн бүртгэлд бүргэсэн. 7 сумын ЗДТГ болон Хүнс хөдөө аж ахуйн газрын мэргэжилтэн нартай хамтран ажиллаж "Малчдын нэгдсэн зөвлөгөөн"-д оролцож бичил уурхайн нөхөрлөл, хоршоо, малчид болон бизнес эрхлэгч нарт улсын бүртгэлийн үйлчилгээний талаар зөвлөгөө мэдээллээр хангаж, Шинэ хоршоо хөдөлгөөнийг сурталчилан 679 гарын авлага хүргүүлж хамтран ажилласан.	100%
4.4.	Төрийн бус байгууллагуудын 2024 оны үйл ажиллагааны тайланг хүлээн авах	Үйл ажиллагаа	Тайлан хүлээн авсан тоо	30	36	Тайлант хугацаанд 37 хуулийн этгээд 2024 оны үйл ажиллагааны тайланг ирүүлсэн.	100%
4.5.	Орон нутгийн хэмжээнд санхүүгийн тайланг 8 баттүүнээс дээш улирал дараалан гаргаагүй, харилцагч санхүүгийн байгууллагад илгээж баталгаажуулаагүй, шинэчилсэн бүртгэлд хамрагдаагүй хуулийн этгээдийг Сангийн яамны саналыг үндэслэн хуульд заасан хугацаанд улсын бүртгэлээс хасах ажлыг зохион байгуулах	Үйл ажиллагаа	Улсын бүртгэлээс хасагдсан хуулийн этгээдийн тоо	0	50	Сангийн яамны хасагдах хуулийн этгээдийн жагсаалтад орсон 2 хуулийн этгээдээс улсын бүртгэлээс хасагдахгүй байх талаар ирүүлсэн хүсэлтийг нь хүлээн авч хууль журмын дагуу УБЕГ-ын Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн газарт хүргүүлсэн. Мөн Сангийн яамны саналыг үндэслэн хуульд заасан хугацаанд улсын бүртгэлээс хасах жагсаалтад орсон 3 хуулийн этгээдэд урьдчилан мэдэгдсэн.	100%

ЗОРИЛТ 5. АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР ХЭРЭГЖҮҮЛНЭ

5.1.	Улсын бүртгэлийн хэлтсийн 2025 оны Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулан батлуулах, хэрэгжилтийг хангаж ажиллах	Үйл ажиллагаа	Хэрэгжилтийг хангасан хувь	1	1	Авлигатай тэмцэх үйл ажиллагааны хөтөлбөрийг хэлтсийн даргаар 2025.03.28-ны өдөр батлуулж, нийт албан хаагчдад төлөвлөгөөг хэрэгжүүлж ажиллах талаар мэдээллийг хүргүүлсэн. Төлөвлөгөөний хэрэгжилтийг эхний хагас жилийн байдлаар гаргаж УБЕГ-т холбогдох хаягаар мэйл хүргүүлсэн.	100%	
5.2.	Авлигын эсрэг хууль тогтоомжийг иргэдэд сурталчлах, гэгээрүүлэх ажиллагааны хүртээмжийг нэмэгдүүлэх	Үйл ажиллагаа	АТГ-аас бэлтгэсэн тв шторк, инфографик, видео график, нийтлэл, төлө зохиомж, хөдөлгөөнт зураг, зурагт хуудас, цахим ном, гарын авлага зэргийг албан ёсны цахим хуудас болон нийгмийн сүлжээ, мэдээллийн самбарт байршуулж, олон нийтэд хүргэсэн тоо	-	5	Хэлтсийн албан хаагчдад авлигын эсрэг хууль, тогтоомж, гарын авлагыг тараан, өрөө бүрт Авлигатай тэмцэх газраас эрхлэн гаргасан "Нэгдье" зурагт хуудсыг байршуулж урьдчилан сэргийлэх сурталчилгаа, соён гэгээрүүлэх арга хэмжээг зохион байгуулсан. Мөн дараах зурагт хуудсыг үйлчилгээний заал болон мэдээллийн самбарт байршуулсан. Үүнд: <ul style="list-style-type: none"><li>- "Иргэн та бүртгэлийн үйлчилгээний хураамжийг зөвхөн банк болон Гэрэгэ киоск машинд тушаах",</li><li>- "Манай үйлчилгээнд яаралтай бүртгэлийн хураамж байхгүй болохыг танд мэдэгдэж байна",</li><li>- Бид авилга авахгүй, та авилга өгөх хэрэггүй, бид танд үйлчлэх үүрэгтэй"</li><li>- "Иргэн танд ёсзүйн зөрчлийн талаарх гомдол, мэдээлэл байвал бичгээр хандана уу"</li><li>- Барел үсгээр Иргэн та дараах тохиолдолд АТГ-т хандах боломжтой,</li><li>- АТГ-ын мэдээлэл хүлээн авах 110 дугаар зэргийн мэдээллийг агуулсан хуудсыг байршуулсан.</li></ul>	100%	
5.3.	Улсын бүртгэлийн албан хаагчдын хуулийн мэдүүлэх	ХАСХОМ-ыг хугацаанд	Үйл ажиллагаа	ХАСХОМ мэдүүлсэн албан хаагчийн тоо	24	25	ХАСХОМ гаргахад анхаарах асуудал сэдвээр сургалтыг УБЕГ-аас цахим хэлбэрээр зохион байгуулсан. Хэлтсийн 26 албан тушаалтны 2024 оны ХАСХОМ-ийг албан хаагчдаар гаргуулан, ХАСХОМ-1, ХАСХОМ хураангуй, ХАС-ын хураангуй тайланг УБЕГ-ын Тамгын газрын	100%

						хариуцсан ажилтны албан мэйлээр хаяг болох цахимаар илгээсэн.	
<b>ЗОРИЛТ 6. ЧАДАХУЙН ЗАРЧИМД СУУРИЛСАН ХҮНИЙ НӨӨЦИЙГ БҮРДҮҮЛЖ, АЛБАН ХААГЧДЫН НИЙГМИЙН БАТАЛГААГ ХАНГАНА.</b>							
6.1.	Хэлтсийн 2025 онд зохион байгуулах сургалтын төлөвлөгөөг боловсруулж батлуулах, хэрэгжилтийг хангаж ажиллах	Үйл ажиллагаа	Сургалтын төлөвлөгөөний биелэлтийн хувь	98%	100%	Хэлтсийн сургалтыг төлөвлөгөөг боловсруулсан бөгөөд нийт 16 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөн ажиллаж байна. Тус төлөвлөгөөний дагуу сүмдын улсын бүртгэгч наарт 2 удаагийн танхимиын, 3 удаагийн цахим сургалтыг тус тус гүйцэтгэсэн. Мөн УБЕГ-аас зохион байгуулсан танхимиын 2, цахим 2 сургалтад тус тус хамрагдсан. Цаашид батлагдсан төлөвлөгөөний дагуу албан хаагчдыг сургах, чадавхижуулах сургалтыг зохион байгуулан төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж ажиллана.	100%
6.2.	Улсын бүртгэлийн хэлтсийн "Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах үйл ажиллагааны төлөвлөгөө"-г боловсруулж батлуулах, хэрэгжилтийг хангаж ажиллах	Үйл ажиллагаа	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	50%	100%	Улсын бүртгэлийн хэлтсийн албан хаагчдын ажиллах нөхцөл нийгмийн баталгааг хангах үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан 7 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөн ажиллаж байна. Тус төлөвлөгөөний дагуу ажиллах нөхцөл сайжруулах арга хэмжээг хэрэгжүүлэхээр аймгийн Засаг дарга болон ЗДТГ-ын Хуулийн хэлтэс, УБЕГ-ийн дарга, холбогдох нэгж, аймгийн барилгын компанийн удирдлага наратай тус тус уулзалт хийж хэрэгжилтийг ханган ажиллаж байна.	100%
6.3.	Монгол хэлний тухай хууль, Засгийн газрын 2020 оны 96 дугаар тогтоолын хэрэгжилтийг ханган албан хэргийг кирилл болон үндэсний хос бичгээр хөтөлсөн хувь	Үйл ажиллагаа	Албан хэргийг кирилл болон үндэсний хос бичгээр хөтөлсөн хувь	-	100%	Хэлтсийн хэмжээнд боловсруулагдаж буй албан хэргийг кирилл болон үндэсний хос бичгээр хөтөлнө хэрэгжилтийг ханган ажиллаж байна.	100%
6.4.	Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2024 оны A/110 дугаар тушаалаар баталсан "Хамгийн чухал нь" зорилтот арга хэмжээний хэрэгжилтийг хангаж Дорноговь аймгийн Нэгдсэн эмнэлэгт 2025 оны 04 дүгээр сарын 09,10-нд сумын улсын бүртгэгч нарыг, 04 дүгээр сарын 26-нд хэлтсийн албан хаагчид, Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн	Үйл ажиллагаа	Эрүүл мэндийн үзлэг, оношилгоонд алба хаагчдын хамрагдсан хувь	-	90%	Хууль, зүй дотоод хэргийн сайдын 2024 оны A/110 дугаар тушаалаар баталсан "Хамгийн чухал нь" зорилтот арга хэмжээний хэрэгжилтийг хангаж Дорноговь аймгийн Нэгдсэн эмнэлэгт 2025 оны 04 дүгээр сарын 09,10-нд сумын улсын бүртгэгч нарыг, 04 дүгээр сарын 26-нд хэлтсийн албан хаагчид, Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн	100%

	туссан холбогдох үйл ажиллагааг хэрэгжүүлэх					эмнэлэг баг бүрэлдэхүүн тус аймагт ирж 2025 оны 05 дугаар сарын 22-нд эрүүл мэндийн эрт илрүүлэг, үзлэг оншилгоонд албан хаагчдыг бүрэн хамруулсан.	
6.5.	Алба хаагчдын болоод тэдээрийн гэр бүл төрөл төрөгсдийн нийгмийн баталгааг хангах, учирсан эрсдлийг даван туулах чиглэлээр ажил зохион байгуулах	Үйл ажиллагаа	Төрийн болон төрийн бус байгууллага, хамт олноос алба хаагчдын нийгмийн баталгааг хангахаар зохион байгуулсан арга хэмжээний тоо	2	3	Тус хэлтсийн албан хаагчдын ажиллах нөхцөлийг дэмжих, нийгмийн баталгааг хангах зорилтын хүрээнд аймагт үйл ажиллагаа явуулдаг барилгын Энержи прагон ХХК-тай уулзалт хийж тус хэлтсийн албан хаагчдад хөнгөлөлттэй үнээр байр захиалах боломжийг бүрдүүлж М2 тутмаас 100 мянган төгрөгний хөнгөлөлт үзүүлхээр шийдвэрлэсэн. Мөн аймгийн Засаг даргын орлогч Г.Марттай уулзалт зохион байгуулж албан хаагчдыг түрээсийн орон сууцанд хамруулах талаар хэлэлцэж албан хаагчдын саналыг хүргүүлсэн.	100%

**ЗОРИЛТ 7. УЛСЫН БҮРТГЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЭРХ ЗҮЙН ОРЧНЫГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОЖ, УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХУУЛЬ ТОГТООМЖИЙГ ХЭРЭГЖҮҮЛНЭ.**

7.1.	Улсын бүртгэлийн хэлтэст ирүүлсэн санал, өргөдөл, гомдол, албан бичгийг хуулийн хугацаанд шийдвэрлэх	Үйл ажиллагаа	Шийдвэрлэсэн өргөдөл гомдлын хувь	98%	100%	Тус байгууллагад хагас жилийн байдлаар 32 иргэний өргөдөл, гомдол, санал, хүсэлтийг хүлээн авч, бүртгэлийн хяналтын карт хетлэн хариуцсан албан хаагчид шилжүүлэн, өргөдлийг 100% шийдвэрлэн ажилласан. Хугацаа хэтэрч шийдвэрлэсэн өргөдөл, гомдол, санал, хүсэлт байхгүй.	100%
			Хариутай албан бичгийн шийдвэрлэлтийн хувь	90%	95%	Хагас жилийн байдлаар нийт ирсэн албан 519 албан бичиг ирсэн бөгөөд үүнээс хариутай 264 албан бичгийг тухай бүр хууль, журмын дагуу шийдвэрлэн ажилласан.	100%
7.2.	Байгууллагын үйл ажиллагааг цахим болон хэвлэл, мэдээллийн хэрэгслийн сурталчилах	Үйл ажиллагаа	Байгууллагын веб хуудсан байршуулсан мэдээ, шторк, постерийн тоо	15	55	Аймгийн хэмжээнд “Мэдлэг түгээ”, “Мэдээлэл түгээ” аяныг эхлүүлэн үе шаттайгаар зохион байгуулан ажиллаж байна. Энэ ажлын хүрээнд хэлтсээс үзүүлж буй хугацаатай бүртгэлийн мэдээллийг иргэд, олон нийтэд мэдлэг олгох үүднээс “МЭДЛЭГ ТҮГЭЭ” аян, байгууллагаас гарч байгаа мэдээ, мэдээллийг иргэд олон нийтэд сурталчилан “МЭДЭЭЛЭЛ ТҮГЭЭ” аяныг зохион байгуулан ажиллаж байна. Тайлант хугацаанд 5 сарын статистик тоон мэдээ, контент-3, рийл-3,	100%

						видео ярилцлага-4, постер-19, пост-17, УБЕГ болон бусад мэдээ, мэдээллийг цахимд байршуулж 269796 иргэнд мэдээлэл хүргэсэн байна.	
7.3.	УБЕГ-аас болон бусад байгууллагаас зохион байгуулсан сургалтад хамрагдах	Үйл ажиллагаа	Хамрагдсан сургалтын тоо	8	10	УБЕГ болон бусад (авилга, хүний эрхийн комисоос "Хүүхдийн хүчирхийлэл", Тагнуулийн хэлтэс, АЗДТГ) байгууллагаас зохион байгуулсан танхимын болон цахимын нийт 10 сургалтад хэлтсийн дарга, тасгийн дарга болон зарим албан хаагчид хамрагдсан.	100%
7.4.	Улсын бүртгэлийн хэлтсийн хэмжээнд дагаж мөрдөх дүрэм, журам зааврыг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн боловсруулж, батлуулах	Үйл ажиллагаа	Боловсруулж батлуулсан журам, зааврын тоо	0	1	Засгийн газрын 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 243 дугаар тогтоолоор "Ахмадын сан байгуулан ажиллуулах журам" шинэчлэгдсэн тул хэлтсийн даргын 2024 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн "Ахмадын сан байгуулан ажиллах журам" А/18 дугаар тушаалыг хүчингүй болгохоор дахин "Ахмадын сан байгуулан ажиллуулах журам"-ын төслийг боловсруулсан. Мөн хэлтсийн албан хаагчдаас санал авч "Хамтын сан" журмын төслийг боловсруулан нийт албан хаагчдаас санал авч хэлтсийн даргын тушаалаар баталсан.	100%
7.5.	Эд хөрөнгө, хуулийн этгээд, иргэний улсын бүртгэлийн статистик тоон мэдээг нэгтгэн хүргүүлэх.	Үйл ажиллагаа	Батлагдсан маягтын дагуу статистик тоон мэдээг улсын хэмжээнд нэгтгэж, хүргүүлсэн тоо.	12	12	Эд хөрөнгө, хуулийн этгээд, иргэний улсын бүртгэлийн статистик тоон мэдээг нэгтгэн сар бүрийн 25-ны өдрөөр тасалбар болгон УБЕГ-т хүргүүлсэн.	100%
7.6.	Хууль тогтоомжийн дагуу холбогдох этгээдэд улсын бүртгэлийн мэдээ тайлан, мэдээлэл хүргүүлэх, шаардлагатай бүртгэлийн мэдээ, тайланг гаргаж, удирдлагыг мэдээллээр хангах	Үйл ажиллагаа	Холбогдох байгууллагуудад хүргүүлсэн мэдээний тоо	2	4	Хөдөлмөр халамж үйлчилгээний газар, Нийгмийн даатгалын газарт сар бүрийн мэдээгээр бүртгэгдсэн иргэдийн мэдээлэл хүргүүлэн ажилласан. Мөн аймгийн Засаг даргад сар бүр хийсэн ажлын танилцуулгыг хураангуй хэлбэрээр гарган хүргүүлж удирдлагыг мэдээллээр ханганд ажилласан. Аймгийн Татварын газарт эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн талаарх судалгааг улирал бүр гарган хүргүүлсэн.	100%
7.7	Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан "Тэрбум мод" үндэсний	Үйл ажиллагаа	Тарьж ургуулсан модны тоо	20	40	"Тэр бум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд тус байгууллага нь 950 хайлаас тод тарьсан. Үүнд: Дорноговь аймгийн Хамрын хийдийн З замын уулзвар Хилэнцэт хөшөөний дэргэд байрлахаялал	100%

	хөтөлбөрийг дэмжин ажиллах				жуулчлалын бүсийн ногоон байгууламжид 50 хайлаас, Хамрын хийдэд байрлах "Энергийн элс" жуулчны баазад 100 хайлаас, иргэн С.Лхагвасүрэн мөн Д.Золбаяр нарын хашаанд хүлэмжийг тойруулан 800 ширхэг хайлаас мод тус тус тарьсан.	
--	----------------------------	--	--	--	--	--

Төлөвлөгөөний биөлэлтийг үнэлсэн:

УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН

ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ .....

(албан тушаал)

(гарын үсэг)

Төсвийн шууд захирагч

/У.БОЛДХҮҮ/

(огноо)

Тэмдэг

Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн:

БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТ, ДҮН ШИНЖИЛГЭЭНИЙ ГАЗРЫН ДАРГА

(албан тушаал)

Нэгжийн дарга

/Т.ГАНТӨМӨР/

(гарын үсэг)

(огноо).....

Тайлاغнасан:

УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН ДАРГЫН АЛБАН

ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ .....

(албан тушаал)

Нэгжийн дарга

/С.ЭНХ-ЭРДЭНЭ/

(гарын үсэг)

(огноо).....



**ДОРНОГОВЬ АЙМГИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН ДАРГЫН  
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ СУМЬЯАГИЙН  
ЭНХ-ЭРДЭНИЙН 2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН  
АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛ, ҮР ДҮН, МЭРГЭШЛИЙН ТҮВШИНГ  
ҮНЭЛЭХ ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС**

Байгууллагын нэр: Улсын бүртгэлийн ерөнхий газар  
Нэгжийн нэр: Дорноговь аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс

**1. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт**

Д/д	Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээ	Гүйцэтгэлийн түвшин	Нийт (70 оноо)
1	2	3	4
1.	Нэгжийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт		57.19

**2. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт**

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Арга хэмжээний биелэлтийн хувь	Төсвийн шууд захирагчийн өгсөн үнэлгээ (15 хүртэл оноогоор)
1.	Арга хэмжээ 1	100	15
2.	Арга хэмжээ 2	100	15
3.	Арга хэмжээ 3	100	
Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний дундаж оноо			15

**3. Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ**

Д/д	Үзүүлэлт	Төсвийн шууд захирагчийн өгсөн үнэлгээ (15 хүртэл оноогоор)
1.	Хандлага, ёс зүй	15
2.	Удирдан зохион байгуулах	15
3.	Асуудал шийдвэрлэх	15
4.	Манлайлах	15
5.	Багаар ажиллах	15
6.	Харилцаа	15
Ур чадварын үзүүлэлт (ажлын онцлогоос хамаарсан)		
7.	Мэргэжлийн ур чадвар 1.	15
8.	Мэргэжлийн ур чадвар 2.	15
9.	Мэргэжлийн ур чадвар 3.	15
Хандлага, ёс зүй, ур чадварын дундаж оноо		15

**4. Гүйцэтгэлийн үнэлгээ**

Д/д	Үнэлгээний үзүүлэлт	Үзүүлэлт тус бүрийн оноо

1.	Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт (Нэгжийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт)	70 хүртэлх оноо 57.19
2.	Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт (Төсвийн шууд захирагчийн үнэлгээ )	15 хүртэлх оноо 15
3.	Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ (Төсвийн шууд захирагчийн үнэлгээ )	15 хүртэлх оноо 15
4.	Үнэлгээний оноонд орсон өөрчлөлт (Аргачлалын 6 дугаар хэсэгт заасан холбогдох заалтыг бичих)	..... оноо
	Нийт оноо = ( Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний оноо + Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний оноо + Хандлага, ёс зүй, ур чадварын оноо ) - Аргачлалын 6 дугаар хэсгийн холбогдох заалтын дагуу хассан оноо	84.19.

Үнэлгээ өгсөн:

Төсвийн шууд захирагч

УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН  
ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ГАЗРЫН ДАРГА

У.БОЛДХҮҮ

ХТУ7852 8034070500 8265720

(огноо)

Үнэлгээтэй танилцуаж,  
зөвшөөрсөн:

Нэгжийн дарга:

ДОРНОГОВЬ АЙМГИЙН УЛСЫН  
БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН ДАРГЫН АЛБАН  
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

С.ЭНХ-ЭРДЭНЭ

9029311  
ГСТ7460 0623016010

(огноо)